

# Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ မူ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

## こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません

指導・元世田谷区立  
小学校教諭  
高橋 侑子  
イラスト・奈良 恵

「今年」をもとにして、前や後の  
年や日の言い方を書きましよう。

前  
の  
年  
後  
の  
年

答えはP22にあります。

# Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2021 оны 1 дугаар сар, Өвлийн дугаар

## Шинэ төрлийн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс

Өнөөдөр (2020 оны 11 дүгээр сар) шинэ төрлийн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх шаардлагатай байдал үргэлжилсэн хэвээр байна. Ур чадварын дадлагажигч Та бүхэн мөн халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээг өдөр тутамд авч байгаа болов уу. Байрандаа байхдаа халдварлахаас хэрхэн сэргийлэх талаар Та бүхэнд анхааруулах зүйлсийг нэгтгэн, Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (OTIT)-аас гаргасан “Шинэ төрлийн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс”-ээс энд нийтэллээ.

### Ажилдаа явахын өмнө

- ✓ Халууны шилээр биеийн халуунаа хэмжиж, 1. 37.5°C-ээс дээш халуунтай, 2. Бие сульдаж ядарсан гэх мэт ханиадны шинж тэмдэг илэрч буй зэрэг биеийн байдал хэвийн бус байвал, Ур чадварын дадлагын удирдагч, Ахуй амьдралын зөвлөгч рүүгээ холбоо барьж мэдэгдэх.

### Гадагшаа гарахдаа

- ✓ Биеийн байдал тааруу үед гадагшаа гарахаа болих.
- ✓ Гадагшаа гарахдаа амны хаалт зүүх.

### Гаднаас орж ирэхдээ

- ✓ Гараа савангаар сайтар угаах. Өөрийн хувийн алчуурыг хэрэглэх.
- ✓ Хэрэглэсэн амны хаалт болон салфетка, бээлий зэргийг хаяхдаа бусад хүн хүрэхээргүйгээр, хогны уутныхаа амыг сайн баглаж хаях.

### Хүнтэй хамт амьдардаг тохиолдолд

- ✓ Гэртээ байхдаа ч хүн хоорондын зай (2 метр) барих.
- ✓ Хүнтэй ярихдаа амны хаалт зүүж, чанга дуу гаргахгүй байх.
- ✓ Ханиалгаж, найтаасны дараа гараа угаах. Өөрийн хувийн алчуурыг хэрэглэх.
- ✓ Нэг цагт 2 удаа цонхоо онгойлгож, цэвэр агаар оруулах.
- ✓ Бусад хүнтэй хамтран хэрэглэдэг эд зүйлс (удирдагч, хөргөгч, гэрлийн унтраалга, үсний сэнс)-ийг хэрэглэснийхээ дараа ариутгах.
- ✓ Жорлонд орсны дараа тагийг нь таглаж, усыг нь татах.

### [Хоол идэхдээ]


- ✓ Хоол идэхийнхээ өмнө болон дараа гараа угаах.
- ✓ Хоолыг хүн бүр тусдаа аяга тавганд аягалах.

### [Усанд орохдоо]

- ✓ Өөрийн хувийн алчуурыг хэрэглэх.
- ✓ Ванны өрөөг нэг нэгээрээ ээлжилж ашиглах.

### [Унтахдаа]

- ✓ Нэг өрөөнд бусад хүнтэй унтах тохиолдолд, аль болох зайтай унтах.
- ✓ Толгойгоо аль болох өөр өөр зүг рүү харуулж унтах.

 Шинэ төрлийн коронавируст халдварын талаар (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага) <https://www.otit.go.jp/CoV2/>

Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээ болон ахуй амьдралын зөвлөгөө, оршин суух эрх зэрэг зүйлсийн талаар Та бүхний эх хэл болон анхан шатны Япон хэл дээр уншиж танилцах боломжтой.

## ЈИТСО-гийн Япон хэлний зохион бичлэгийн уралдаанд оролцож үзээрэй

ЈИТСО нь “Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”-ыг жил бүр зохион байгуулдаг. Япон хэлээр зохион бичлэг бичих нь хялбар зүйл биш хэдий ч, энэ удаа танилцуулж буй сайн зохион бичлэг бичихэд санаа авах зүйлстэй танилцан, зохион бичлэг бичиж үзээрэй.

2021 оны Япон хэлний зохион бичлэгийн уралдааны удирдамжийг 2 дугаар сарын эхэн үеэр ЈИТСО-гийн цахим хуудсаар зарлахаар товлож байна. Та бүхнийг идэвхтэй оролцохыг урьж байна!

Зохион бичлэг бичиж үзээрэй!

### ⇒ Нэг л зүйлийн талаар сонгож бичих

Та бүхэн Японд ирээд хөгжөөнтэй, гунигтай явдлууд, гайхах, хүнд хэцүү санагдах зүйл гээд өдөр бүр янз бүрийн юм үзэж туулж байгаа гэж бодож байна. Зохион бичлэг бичихдээ, олон үйл явдлынхаа дотроос нэг л зүйлийг сонгох хэрэгтэй. Юу болсон, хэн юу гэж хэлсэн, өөрөө юу гэж бодсон гэх зэргээр тодорхой бичвэл бодол санаа тань уншигчдад хүрнэ.

### ⇒ Зөвхөн таны л бичиж чадах зүйлийн талаар бичих

“Японы зам нь их цэвэрхэн.” гэх мэтийн хялбар бөгөөд товчхон сэтгэгдэл бол, өөр олон хүн ижил төстэй зүйл бичих магадлалтай. Сайн зохион бичлэг бичихийн тулд, тухайлбал, “Японы зам нь цэвэрхэн байдгийн учрыг ажлын газрынхаа хүнээс асууж үзлээ.” гэх мэтээр өөрийнхөө тодорхой туршлагатай холбож бичих нь чухал юм.

### ⇒ Сэдвээ сайн бодож байж өгөх

“Миний амьдрал”, “Японы дурсамж” гэх мэт хэт ерөнхий сэдэв бус, уншигчдад “Энэ юуны тухай зохион бичлэг юм бол?” гэж бодогдохуйц, уншиж үзэх сонирхлыг нь өдөөхүйц сэдэв өгөх.

🌐 Өмнөх онуудын Япон хэлний зохион бичлэгийн уралдааны шагналт байранд орсон бүтээлүүдийг эндээс харах боломжтой.

Өмнөх онуудын Япон хэлний зохион бичлэгийн уралдааны шилдэг бүтээлийн цомог

[https://www.jitco.or.jp/ja/service/guidebook/#contest\\_pc](https://www.jitco.or.jp/ja/service/guidebook/#contest_pc)

“Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”-ийн цахим хувилбарын “Япон хэл, Японы соёл” > “Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн уралдаан”

<https://www.jitco.or.jp/webtomo/>

## Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Галт тэргээр чатлаж байна —



Маруй сан, хажуугийн хүнийхээ анхааруулсныг, ойлгож хүлээн авахгүй байгаа бололтой боловч ...

Корона дэгдсэн ийм нөхцөлд, метрогоор зорчихдоо утсаар ярихаас ч, найзууд хоорондоо ярихаас ч татгалзвал зүйтэй болов уу.

